



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 25
№12 /1114/

**Монгол Улсын
хууль**

**Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг
соёрхон батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Төрөөс аялал жуулчлалыг
хөгжүүлэх талаар баримтлах
бодлого батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

Үндэсний хөтөлбөр батлах тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

141. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай 701

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

142. Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай Дугаар 333 702

143. Үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 335 716

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

144. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн Түрэмгийллийн гэмт хэргийн тухай нэмэлт, өөрчлөлт 725

145. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн Дайны гэмт хэргийн тухай 8 дугаар зүйлийн нэмэлт 728

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

**ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн Түрэмгийллийн гэмт хэргийн тухай болон Дайны гэмт хэргийн тухай нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 333

Улаанбаатар
хот

Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 16.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжид хамруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг нэгтгэн жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.ЦЭРЭНБАТ

Засгийн газрын 2019 оны
333 дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, дэлхийн нийтийн экспортын 7 хувь (1,6 их наяд

ам.доллар), үйлчилгээний экспортын 30 хувийг тус тус бүрдүүлж, ажил эрхэлж байгаа 10 хүн тутмын 1 нь тус салбарт ажлын байраар хангагдаж, шинээр бий болж байгаа 5 ажлын байр тутмын 1 нь аялал жуулчлалын салбарт бий болжээ.

Нэгдсэн үндэстний байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан статистик мэдээллээс үзэхэд 2017 онд олон улсад 1,3 тэрбум жуулчин аялж, тэдгээрээс 1,3 их наяд ам.долларыг зарцуулсан бөгөөд 2030 он гэхэд олон улсын жуулчдын тоо 1,8 тэрбумд хүрэх төлөвтэй байна.

1950 онд дэлхий дахинд 25 сая гаруй жуулчин аялж байсан бол 2017 онд энэ тоо 1,3 тэрбумд хүрснээс үзэхэд 67 жилийн хугацаанд жуулчдын тоо 50 дахин өссөн байна.

Олон улсын аялал жуулчлалын 2018 оны үзүүлэлтийг бүс нутгаар авч үзвэл нийт жуулчдын 51 хувь буюу 672 сая жуулчин Европын улсуудаар аялж 519 тэрбум ам.доллар, 24 хувь буюу 323 сая жуулчин Ази, Номхон далайн улсуудаар аялж 390 тэрбум ам.доллар, 16 хувь буюу 211 сая жуулчин Америк тивийн улс, орнуудаар аялж 326 сая ам.доллар, 5 хувь буюу 63 сая жуулчин Африкийн орнуудаар аялж 37 тэрбум ам.доллар, 4 хувь буюу 58 сая жуулчин Ойрхи дорнодын орнуудаар аялж 68 тэрбум ам.долларыг аялалдаа зарцуулжээ.

Нийт аялж байгаа жуулчдын 55 хувь нь аялах, амрах зорилгоор, 27 хувь нь эргэн дурсах, найз нөхдөдөө зочлох, эрүүл мэндийн зорилгоор, 13 хувь нь албан, бизнесийн зорилгоор, 6 хувь нь бусад зорилгоор аялдаг бөгөөд мөн нийт жуулчдын 57 хувь нь агаарын, 37 хувь нь авто, 4 хувь нь усан, 2 хувь нь төмөр замын тээврээр үйлчлүүлж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн хувьд сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбар хурдацтай өсөж, бүсийн дотоодын нийт бүтээгдэхүүний 9,8 хувийг, нийт ажлын байрны 9,3 хувийг тус тус аялал жуулчлалын салбар бүрдүүлж, 2017 онд 323 сая жуулчин хүлээж авч, 390 тэрбум ам.долларын орлого олсон нь 2016 онтой харьцуулахад 6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэдийгээр бүс нутаг дотроо Зүүн өмнөд Ази болон Номхон далайн орнуудын аялал жуулчлалын хөгжил эрчимжиж, жуулчдын өсөлт 6-9 хувьд хүрсэн ч Төв Азийн орнуудын хувьд аялал жуулчлалын өсөлт дунджаар 3 хувь байна.

Тус бүс нутагт хүлээн авч байгаа нийт жуулчдын 10 орчим хувийг буюу 30 орчим сая жуулчдыг Төв Азийн орнууд хүлээн авч байгаа нь харьцангуй бага үзүүлэлт юм.

Төв Азийн орнууд газар зүйн хувьд Ази, Европыг холбосон давуу байрлалтай, байгаль, түүх, соёлын хувьд харьцангуй өндөр нөөцтэй хэдий



ч дэд бүтэц сул хөгжсөн, улирлын хамаарал ихтэй, мөн олон улсын аялал жуулчлалын зах зээлд бага танигдсан зэрэг сул талууд их байна.

Иймд эдгээр асуудлуудыг хамтран шийдвэрлэх замаар Ази, Номхон далайн бүс нутгийг зорих жуулчдын урсгалаас Төв Азийн орнуудад чиглэх урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр “CAREC”-ийн хүрээнд 2018 оноос Аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хэсэг байгуулан, Монгол Улс хамтран ажиллахаар тогтоод байна.

Түүнчлэн Төв Азийн орнууд жуулчид аялах нөхцөлийг хөнгөвчлөх, хил дамнасан аялал жуулчлалыг дэмжих зорилгоор олон улсад танигдсан Торгоны замын аялал жуулчлалыг брэнд болгон хөгжүүлж, “Торгоны зам” визийг нэвтрүүлж эхлээд байна.

Монгол Улсын хувьд 2018 онд 529 мянган гадаадын жуулчин хүлээн авч, дотоодын эдийн засагт 569 сая ам.доллар буюу 1,5 их наяд төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь 2017 онтой харьцуулахад жуулчдын тоо 12, салбарын орлого 42 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсад ирж байгаа гадаадын жуулчин дунджаар 9 хоног аялж, нэг удаагийн аялалдаа 1,460 орчим ам.долларыг (олон улсын тээврээс гадна) зарцуулж байна.

Монгол Улсад ирж байгаа гадаадын жуулчдын 34 хувь нь байгаль, 24 хувь нь уламжлалт нүүдэлчдийн ахуй соёл, 12 хувь нь адал явдал, 11 хувь нь ан амьтан ажиглах, 10 хувь нь монголын түүх, 9 хувь нь бусад шалтгаанаар аялдаг байна.

Мөн нийт гадаадын жуулчдын 36 хувь нь зун, 33 хувь нь намар, 16 хувь нь хавар, 15 хувь нь өвөл аялдаг бөгөөд нийт жуулчдын 47,3 хувь нь агаарын, 41,5 хувь нь авто, 11,2 хувь нь төмөр замын олон улсын тээврээр хил нэвтэрсэн байна.

Улсын хэмжээнд 2019 оны байдлаар бүртгэлтэй 270 орчим тур оператор компани, 460 гаруй зочид буудал, 400 гаруй жуулчны бааз үйл ажиллагаа явуулж салбарт 34 мянга орчим ажлын байрыг бий болгосон байна. Жуулчинд байр сууцны үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын 43,4 хувь нь хангайн бүсэд, 26,6 хувь нь төвийн бүсэд, 19,3 хувь нь Улаанбаатарын бүсэд, 5,5 хувь нь зүүн бүсэд, 5,2 хувь нь баруун бүсэд байрлалтай байна.

Жуулчин хүлээж авах өнөөгийн ор/хоногийн даацыг тооцоолж үзвэл Монгол Улс нэг хавар, намар, зуны улиралд, өдөрт 72 гаруй мянган

жуулчин хүлээж авах хүчин чадалтай, бөгөөд жуулчдын дүүргэлт 100 хувь байх тохиолдолд 5-аас 9 дүгээр сар хүртэл 5 сарын хугацаанд нийт 1,2 сая гаруй жуулчин, хүлээж авах бүрэн хүчин чадалтайг илтгэж байна.

Гэвч олон улсын агаарын тээврийн хязгаарлагдмал боломж, визийн хүндрэлтэй байдал, дэд бүтцийн асуудлуудаас шалтгаалан сүүлийн 10 гаруй жилийн турш Монгол Улсад ирж байгаа гадаадын жуулчдын тоо 400-480 орчим мянгад хэлбэлзсээр иржээ.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт”-д дэлхийн 136 орноос Монгол Улс 102 дугаарт эрэмбэлэгдсэн бөгөөд дараах шалгуур үзүүлэлтүүдэд харьцангуй доогуур үнэлэгдсэн байна. Үүнд: “олон улсад нээлттэй байдал” 136 орноос 125-д, “агаарын тээврийн дэд бүтэц” 136 орноос 95-д, “газрын боомт, дэд бүтцийн хөгжил” 136 орноос 123-т, “жуулчны үйлчилгээний дэд бүтэц” 136 орноос 111 дүгээрт эрэмбэлэгдсэн.

Аялал жуулчлалын хувьд манай улстай ижил нөөцтэй, нэг бүс нутагт оршдог Казахстан, Узбекистан, Киргизстан зэрэг улсууд цахим визэд шилжсэн, мөн Зүүн өмнөд Азийн Тайланд, Лаос, Мьянмар, Индонез, Филиппин зэрэг улс орнууд жуулчдыг визгүй эсхүл хил дээрээс виз олгох нөхцөлийг бүрдүүлснээр жуулчдын тоогоо тогтмол нэмэгдүүлсэн байна.

Харин 2019 оны байдлаар Монгол Улсад 20 гаруй улсын иргэд визгүй зорчиж байгаа нь харьцангуй бага үзүүлэлт бөгөөд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж байгаа дэлхийн бусад улс орнуудын жишгээр зорилтот зах зээлийн орнуудад хандсан хил дээрээс виз олгох, цахим виз олгох зэрэг визийн хөнгөлөлттэй нөхцөлийг бүрдүүлэх бодлого зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсад 2017 онд аялсан жуулчдын 222 мянга нь олон улсын агаарын тээврээр зорчсон бөгөөд аялал жуулчлалын оргил үе буюу 6-8 дугаар саруудад нислэгийн тийз олддоггүй, олон улсын нислэгийн тийзийн үнэ нэмэгддэг зэрэг олон асуудлууд тулгамдсаар байна.

Мөн гадаадын жуулчдыг хүлээж авах олон улсын агаарын тээврийн ганц боомттойгоос шалтгаалан дундаж аяллын үнэ бүс нутгийн бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас 2019 онд “Аялал жуулчлал”-ын салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэж, хөгжлийг эрчимжүүлэн, салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, цаашид аялал жуулчлалыг бүс нутгуудад жигд хөгжүүлэх замаар орон нутагт тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ыг 2019-2026 онуудад хэрэгжүүлэхээр боловсрууллаа.



Энэ бодлогын баримт бичиг нь аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, бүс нутаг бүрт аялал жуулчлалын хөгжлийг жигд цогцлоох, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн болно.

Бодлогыг хэрэгжүүлэхэд нийт 1 тэрбум орчим ам.доллар шаардлагатай бөгөөд Монгол Улсад ирэх жуулчдын тоог 2020 онд 1 саяд хүргэх зорилтын биелэлтийг хангаснаар жилд аялал жуулчлалын салбараас дотоодын эдийн засагт орох орлогыг 1,4 тэрбумд, улмаар бодлого хэрэгжиж дуусах 2026 онд жилд ирэх жуулчдын тоог 1,7 саяд, салбарын жилийн орлогыг 2,4 тэрбум ам.долларт хүргэх боломж бүрдэнэ.

Хоёр. Бодлогын алсын хараа, зорилго, зорилт,
хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. Бодлогын алсын хараа

Монгол Улс нүүдлийн соёл, түүхэн аялал жуулчлалын олон улсын төв болно.

2.2. Бодлогын зорилго

Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын зорилго нь үндэсний онцлог бүхий, хүрээлэн буй орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

2.3. Бодлогын зорилтууд

2.3.1. аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.3.2. аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх;

2.3.3. аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх;

2.3.4. газар зүйн байрлал, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх;



2.3.5. аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах;

2.3.6. техник, технологи, шинжлэх ухааны дэвшлийг шингээсэн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх.

2.4. Бодлогыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.4.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашиг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын зарчмуудад нийцсэн байх;

2.4.2. Монгол Улсын үндэсний онцлогт тулгуурласан байгаль, түүх, соёлын өвийн үйлдвэрлэлд түшиглэсэн, хадгалах, хамгаалах, өвлүүлэх, сурталчлах;

2.4.3. жуулчдын аюулгүй байдал болон эрүүл ахуй, үйлчилгээний стандартыг хангасан байх;

2.4.4. улирлын хамаарал багатай аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийн цогц байдлыг хангасан байх;

2.4.5. төр, шинжлэх ухаан, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагаанд тулгуурласан, харилцан уялдаатай нэгдмэл цогц байх;

2.4.6. байгаль-экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр унаган төрхийг нь хадгалан зүй зохистойгоор ашиглах;

2.4.7. олон улсад өрсөлдөх чадвартай, дэвшилтэт техник, технологийн хөгжил, инновацид суурилсан тэргүүн туршлагыг хөхиүлэн дэмжсэн байх.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат

3.1. Бодлогыг 2019-2026 онуудад дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

I үе шат: 2019-2022 онд аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, аялал жуулчлалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөх, бүх нийтийн аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгааны ажлыг эрчимжүүлэх, өндөр ур чадвар бүхий боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ зах зээл бий болох боломжийг бүрдүүлэх, маркетинг, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.



II үе шат: 2023-2026 онд аялал жуулчлалын салбарын өсөлтийг баталгаажуулах, инновацид суурилсан эдийн засгийн үр өгөөжтэй салбарыг төлөвшүүлэх, улс орны эдийн засаг, нийгэм, соёл, байгаль экологи, хүний хөгжилд оруулах аялал жуулчлалын үр нөлөөг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. Аялал жуулчлалын салбарын бүтээлч байдал, үр ашгийг дээшлүүлэх, тогтвортой хөгжилд суурилсан эко технологийг нэвтрүүлэх, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэж, олон улсын аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индексийг бүх төрлөөр дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дөрөв. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж, батлуулах;

4.1.2. тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, батлан, ногоон гэрчилгээг олгох;

4.1.3. аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэхэд зориулсан бага хүүтэй “Ногоон зээл”-ийг бий болгох;

4.1.4. аялал жуулчлалын үйл ажиллагааг жижиг, дунд бизнесийн ангилалд хамруулж, төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, олгож байгаа хөнгөлөлттэй зээлд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.5. “Аялал жуулчлалын сан”-г бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэд бүтцийг сайжруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төслүүдийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.1.6. аялал жуулчлалын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын томоохон төслийг хэрэгжүүлэхийг бодлогоор дэмжиж, төслийн тогтвортой, үр ашигтай байх нөхцөлийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.7. аялал жуулчлалын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын тусгай дэглэм бүхий чөлөөт бүсүүдийг байгуулах, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.8. аялал жуулчлалын талаар хэрэгжих төсөл хөтөлбөрүүдэд гаалийн татвар, татвар, тарифын хөнгөлөлтүүдийг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.9. жуулчдад цахим виз олгох, голлох зах зээлийн орнууд хилийн боомт дээрээс виз авах, аялал жуулчлалын тур оператор компаниар үйлчлүүлж байгаа бүлэг жуулчдыг хил орчмын аялал жуулчлалын визийн хөнгөлөлттэй нөхцөлөөр зорчуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.10. агаарын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих;

4.1.11. жуулчдад татварын буцаан олголт олгох, татваргүй барааны бүсийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;

4.1.12. гадаадаас Монгол Улсад, Монгол Улсаас гадаад улс орнуудад аялж байгаа нийт жуулчид, жуулчдад үйлчилгээ үзүүлж байгаа хөтөч, жолооч нарыг даатгалд хамруулах тогтолцоог бүрдүүлэх;

4.1.13. аялал жуулчлалын статистик мэдээллийг тооцоолох “Аялал жуулчлалын дагуул дансны аргачлал”-ыг нэвтрүүлэх;

4.1.14. гадаадын жуулчинд үйлчилгээ үзүүлж байгаа аялал жуулчлалын байгууллагууд, зэрэглэл бүхий зочид буудал, жуулчны баазын үйлчилгээг төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд адил хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4.1.15. аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах хүрээнд аялал жуулчлалын идэвхгүй буюу 9-5 дугаар саруудад ажилладаг жуулчны баазуудад шөнийн цахилгааны хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;

4.1.16. эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Казиногийн тухай, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах;

4.1.17. өндөр уулын бүсэд аялах журам, усан аяллын журмуудыг боловсруулж, мөрдүүлэх.

4.2. Аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Ховд аймгуудын нисэх онгоцны буудлыг олон улсын нисэх буудал болгон



хөгжүүлж, орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж бүсийн зангилаа (hub) буудлуудыг барьж байгуулах;

4.2.2. аялал жуулчлалын гол чиглэл дагуу авто замын сүлжээг сайжруулах, замын тэмдэг, тэмдэглэгээг нэгдсэн стандартын дагуу бий болгох;

4.2.3. аялал жуулчлалын гол чиглэл дагуу үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг батлагдсан стандарт, зураг төслийн дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулах;

4.2.4. аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу төмөр замын дэд бүтцийг хөгжүүлэх, галт тэргээр аялах жуулчдын үйлчилгээний нөхцөлийг сайжруулах;

4.2.5. аялал жуулчлал хөгжиж байгаа томоохон нууруудад усан аяллын нэгдсэн зогсоол бий болгож, тогтсон маршрутын дагуу аялал зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.6. явган аяллын гол чиглэл болон тусгай хамгаалалттай газар нутгийн аяллын зам, жимийг тохижуулах, мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулах;

4.2.7. жуулчид голлон зорих байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад отоглох цэгүүдийг байгуулах;

4.2.8. жуулчдад шаардлагатай мэдээллээр хангах мэдээллийн төв, цэгүүдийг Монгол Улсад нэвтрэх боомтуудад байгуулах;

4.2.9. зарим боомтуудыг олон улсын боомт болгох, газрын боомтуудаар жуулчин нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх;

4.2.10. аялал жуулчлалын гол бүс нутгуудыг эрчим хүчээр хангах;

4.2.11. аялал жуулчлалын идэвхтэй саруудаас бусад үед олон улсын болон орон нутгийн тээврийн (агаарын, төмөр замын, авто замын) үнийн уян хатан, хөнгөлөлттэй нөхцөлөөр дотоод, гадаадын жуулчдад үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх;

4.2.12. аялал жуулчлалын гол бүс нутгуудад байгаль орчинд ээлтэй технологиор хатуу хог хаягдлыг дарж булшлах, шингэн хог хаягдлыг нөөцлөх зориулалтын цэгүүдийг байгуулах;

4.2.13. аялал жуулчлалын гол бүс нутгуудад эко ариун цэврийн газруудыг байгуулах;

4.2.14. аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад байгаль орчинд ээлтэй халаалт, цэвэрлэх байгууламж, ариун цэврийн газрууд, эрүүл ахуйн шаардлага хангасан технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.3. Аялал жуулчлалын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гадаад сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.3.1. Монгол Улсын гадаад, сурталчилгаа, маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.3.2. зорилтот зах зээлийн орнуудын онцлогт тохирсон маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх;

4.3.3. Монгол Улсын гадаад сурталчилгааны цахим платформыг бий болгох, түүнийг хөгжүүлэх;

4.3.4. аялал жуулчлалын сурталчилгааны дүрс бичлэг, зурган контент, гадаад сурталчилгааны хэвлэмэл материалыг боловсруулж түгээх ажлыг зохион байгуулах;

4.3.5. Монгол Улсын соёл, аялал жуулчлалын төвүүдийг зорилтот зах зээлийн орнуудад байгуулах, тогтмол үйл ажиллагаагаар хангах;

4.3.6. олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг сурталчлахад төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

4.3.7. олон улсын нэр хүндтэй, олон үзэгчтэй хэвлэл мэдээллийн агентлагуудаар Монгол Улсын сурталчилгаа нэвтрүүлэх;

4.3.8. олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4.3.9. Монгол Улсын нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээ, хэлэлцээрийн жагсаалтын судалгаа гарган, нэгдэн орох бэлтгэлийг хангаж нэгдэн орох;

4.3.10. Монгол-Орос-Хятад улсын аялал жуулчлалын сайд нарын уулзалтыг жил бүр зохион байгуулж, хамтарсан төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;



4.3.11. хөрш орнуудтай хамтран 1 аялал, 3 улс зэрэг хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх;

4.3.12. торгоны зам, цайны зам, их түмэн голын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөтөлбөрийн гишүүн улс орнуудтай хамтран хөгжүүлэх;

4.3.13. Нэгдсэн үндэстний байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.3.14. Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Төв Азийн орнуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

4.4. Газар зүйн байрлал, байгаль, түүх, соёлын өвд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгийг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуй, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.4.1. баруун бүсэд-адал явдалт, тусгай сонирхлын, хангайн бүсэд-байгалийн, амралт зугаалгын, төвийн болон Улаанбаатарын бүсэд-албан, бизнесийн, говийн бүсэд-байгалийн, палеонтологи, геологи, геофизикийн, зүүн бүсэд-түүхэн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, гол зорих газрууд, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хөгжлийн чиг хандлагыг бүсчлэн тодорхойлох;

4.4.2. байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах чиглэлээр эко, тогтвортой аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож, хөгжүүлэх;

4.4.3. аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр нэн яаралтай хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, батлагдсан төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг бодлогоор дэмжих;

4.4.4. Орхоны хөндийн байгалийн цогцолборт газарт аялал жуулчлалын үндэсний парк бий болгох, Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, Хэнтий аймагт мянганы суут хүн их эзэн Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Дорнод аймагт хил орчмын аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Өмнөговь аймагт палеонтологийн аялал жуулчлалын үндэсний хүрээлэн байгуулах, Ховд аймагт олон ястны соёлын хүрээлэн байгуулах,



Говийн бүсэд аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулах болон бусад төслүүдийг хэрэгжүүлэх замаар орон аялал жуулчлалын эдийн засаг нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

4.4.5. рашаан сувилалд түшиглэсэн эрүүл мэндийн аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлэх;

4.4.6. спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, өндрийн спортын бэлтгэлийн төвийг байгуулах;

4.4.7. нүүдлийн соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.4.8. хил орчмын аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх, хил дамнасан болон хил орчмын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих;

4.4.9. аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг бүсийн хэмжээнд харилцан уялдаатай тогтоож, зохион байгуулах ажлыг тогтмолжуулах, цар хүрээг өргөжүүлэх;

4.4.10. аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.4.11. Улаанбаатар хотод бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.4.12. Улаанбаатар хотод олон улсын жишигт нийцсэн хурал, үзэсгэлэнгийн төв (convention center) байгуулах;

4.4.13. аялал жуулчлалын идэвх багатай 9-5 дугаар сард зохион байгуулагдаж байгаа аялал жуулчлалын арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

4.4.14. шашин, соёл, спорт, адал явдалт аялал, техник, технологи, шинжлэх ухааны дэвшилтийг агуулсан улирлын хамаарал багатай аялал жуулчлалын төрөл хэлбэрийг бодлогоор дэмжих;

4.4.15. морин аяллын стандартыг боловсруулж, мөрдүүлэх, морин аяллын хөтөч нарыг стандарт бүхий хувцас хэрэглэл, тоноглолоор хангах;

4.4.16. аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх;



4.4.17. нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг бодлогоор дэмжиж, аялал жуулчлалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

4.5. Аялал жуулчлалын боловсрол, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлж, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.5.1. Нэгдсэн үндэстний байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) Тогтвортой аялал жуулчлалын тандан судалгааны төвийг Монгол Улсад байгуулах;

4.5.2. дээд боловсролын болон техник мэргэжлийн ажилчдын аялал жуулчлалын мэргэжлийн индексийг шинэчлэх;

4.5.3. аялал жуулчлалын олон улсын жишигт нийцсэн дээд боловсролын хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, их дээд сургуулиудад мөрдүүлэх;

4.5.4. аялал жуулчлалын дээд боловсролын сургалтын жишиг хөтөлбөр, гарын авлага боловсруулах, нэвтрүүлэх;

4.5.5. аялал жуулчлалын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмол хийж, аялал жуулчлалын сургалт, судалгаа, үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлэх;

4.5.6. ажлын байрны стандартад нийцсэн аялал жуулчлалын үйлчилгээний ажилтны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулах;

4.5.7. аялал жуулчлалын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах;

4.5.8. аялал жуулчлалын хүний нөөцийн цахим мэдээллийн санг бий болгож, ажилчдын нээлттэй үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх;

4.5.9. “аялал жуулчлалын салбарын ажиллагсдын ёс зүйн дүрэм”-ийг боловсруулж, батлан мөрдүүлэх;

4.5.10. хөтөчийн ангилал, зэрэглэлийг бий болгож, эрх олгох, гэрчилгээжүүлэх, үйлчилгээний ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалтуудыг хийх;

4.5.11. бүх нийтэд аялал жуулчлалын боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлж, жуулчдаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах.

4.6. техник, технологи, шинжлэх ухааны дэвшлийг шингээсэн, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.6.1. аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг бий болгох;

4.6.2. цахим аялал жуулчлалаар дэлхийд тэргүүлэгч байгууллагуудтай хамтран Монголын цахим аялал жуулчлалын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлуулж, хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.6.3. дотоод, гадаадын жуулчдад зориулсан гар утасны аппликейшн бий болгож, мэдээ, мэдээллийг нэг дороос авах, жуулчдын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

4.6.4. аялал жуулчлалын зорих газрууд, үйлчилгээний байгууллагуудын байршлыг 3 үгт хаягжуулалтад хамруулах замаар дотоод, гадаадын жуулчид гар утасны аппликейшнээр байршлыг хялбар олох нөхцөлийг бүрдүүлэх;

4.6.5. олон улсын болон дотоодын судалгааны ажлуудыг нэгтгэсэн “Аялал жуулчлалын цахим номын сан”-г бий болгох.

Тав. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт

5.1. Аялал жуулчлалын салбарын олон улсад өрсөлдөх чадварын үзүүлэлтийг 102 дугаар байрнаас 85 дугаар байранд хүргэсэн байна.

5.2. Монгол Улсад 1 жилд аялах гадаадын жуулчдын тоог 2022 онд 1,2 сая, 2026 онд 1,7 саяд хүргэсэн байна.

5.3. Аялал жуулчлалын салбарын жилийн орлогыг 2022 онд 1,2 тэрбум ам.долларт, 2026 онд 1,8 тэрбум ам.долларт хүргэсэн байна.

5.4. Аялал жуулчлалын салбар дахь ажлын байрны тоог 2022 онд 85 мянга, 2026 онд 125 мянгад хүргэсэн байна.

Зургаа. Бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр

6.1. Бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;



- 6.1.2. гадаадын зээл, тусламж;
- 6.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 6.1.4. бусад эх үүсвэр.

Долоо. Аялал жуулчлалын хөгжлийн талаар баримтлах бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулан, уялдуулж ажиллана.

7.2. Бодлогыг хэрэгжүүлэгч бүх талууд аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан, мэдээллийн шалгуур, үзүүлэлт тус бүрээр заасан хугацаанд хүргүүлнэ.

7.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.4. Энэ бодлогын баримт бичгийн 4.1.16-д заасан байгууллага нь бодлогоор тодорхойлсон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, тайлан мэдээллүүдийг нэгтгэн, хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хариуцан заасан хугацаанд олон нийтэд тайлагнаж байна.

7.5. Бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайлан мэдээллийг олон нийтэд мэдээлж, сурталчилна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 335

Улаанбаатар
хот

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.2, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, 10.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаадын зээл, тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Цогц хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2011 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ё.БААТАРБИЛЭГ

Засгийн газрын 2019 оны
335 дугаар тогтоолын хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газраас 2011 онд “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлсний үр дүнд идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүмүүсийн үзүүлэлт 2009 онд 11.7 хувь байсан бол 2013 онд 23.1 хувь болж 12.8 пунктээр өсөж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу эрүүл мэндэд тустай идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүн амын тоо 2 дахин нэмэгдсэн үзүүлэлт гарсан байна.¹

Цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улсын тамирчид олимпийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд спортын тодорхой төрлүүдээр амжилттай оролцон, авсан медалийн тоо нэмэгдсэн. Түүнчлэн 2017 оны байдлаар улсын хэмжээнд зохион байгуулагдсан биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд давхардсан тоогоор нийт

¹ ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ. Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын гуравдугаар судалгаа-2013 он. Хуудас 69.



1,118,400 хүн оролцсон² нь 2011 оны (917,912) үзүүлэлтээс 17.9 хувиар өссөн байна.

Цаашид 2022 онд биеийн тамир, спортын үйл ажиллагаанд оролцох боломжтой 6-64 насны иргэдийн тоо 2,757,396 (давхардсан тоогоор) болж өсөх төлөвтэй байгаа тул хүн амын биеийн тамир, спортоор хичээллэх эрэлт хэрэгцээг хангахад спортын салбарын өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүүжилт, заал, талбайн хүртээмжийг сайжруулах шаардлага үүсэж байна.

Улсын Их Хурлаар 2017 онд баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангаж Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоолоор “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг баталсан.

Иймд биеийн тамир, спортын салбарт шинэчлэгдсэн хууль тогтоомж, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т дэвшүүлсэн зорилтын хүрээнд “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж төрийн байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх, салбар хоорондын уялдааг сайжруулах, идэвхтэй хөдөлгөөн, спортыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бүх нийтийн хөдөлгөөн болгон хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, хяналтын механизмыг оновчтой бүрдүүлэх, биеийн тамир, спортын заал, талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

2.1. Спортын шинжлэх ухаан, анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлж, магадлан итгэмжлэгдсэн спортын клубээр дамжуулан төрөөс иргэдэд чанартай үйлчилгээг үзүүлэн, иргэд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. хүн амын зорилтот бүлгүүдийн сонирхол, бодит хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.2.2. спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын

² БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО. Нэгдсэн тайлан-Биеийн тамир, спортын улсын үзлэг тооллого 2017 он. Хуудас 48.

ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;

2.2.3. спортын шинжлэх ухаан, анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх суурь тогтолцоог бүрдүүлэх;

2.2.4. биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн зарим чиг үүргийг олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн спортын холбоо, түүний аймаг, нийслэл, дүүргийн салбар, магадлан итгэмжлэгдсэн спортын клубээр гүйцэтгүүлэх;

2.2.5. биеийн тамир, спортын санхүүгийн менежментийг сайжруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2020-2023 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Хүн амын зорилтот бүлгүүдийн сонирхол, бодит хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өөрийн бие бялдрын хөгжлийг тодорхойлох арга зүйг биеийн тамирын хичээлээр олгодог болох;

3.1.2. ерөнхий боловсролын сургуулийн спортын дугуйлан (секц)-гийн сургалт, түүнийг удирдах багш, дасгалжуулагчдад тавигдах шаардлагыг тогтоож, хөдөлмөрийн хөлсний жишгийг тодорхойлох;

3.1.3. биеийн тамир, эрүүл мэндийн арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш болон эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтнаар дамжуулан хөдөлгөөний хомсдолтой, илүүдэл жинтэй иргэдэд хяналт тавих, биеийн онцлогт тохирсон дасгал хөдөлгөөн хийх арга зүй, жишиг хөтөлбөрийг боловсруулах, хүртээмжийг сайжруулах;

3.1.4. тусгай сургуулийн биеийн тамирын хичээлийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлог, ажиллах чадварт тохирсон спортын төрлүүдийг тусгаж хэрэгжүүлэх, багш, дасгалжуулагчийг мэргэшүүлэх, давтан сургах;

3.1.5. магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клубын тоо болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;

3.1.6. ерөнхий боловсролын сургуулиудыг стандартын спортын заал, талбайтай болгох, спортын хэрэглэлийн хангамж,



хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэглэлээр тоноглох, хяналт тавих;

3.1.7. хүн амын ажиллах, амьдрах орчинд тэдний онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчныг бий болгох, ерөнхий боловсролын сургуулиудын спортын заал, талбайг харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд ашиглуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх санал санаачилгыг өрнүүлэх, дэмжих.

3.2. Спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. спортын сургалт-дасгалжуулалтын (тамирчин бэлтгэх) тогтолцоог боловсронгуй болгож, сургалтын жишиг хөтөлбөр, дасгалжуулагчийн гарын авлага боловсруулж, мөрдүүлэх;

3.2.2. спортын сургалт-дасгалжуулалтыг спортын төрөл бүрээр төлөвлөх нэгдсэн загварыг баталж, мөрдүүлэх;

3.2.3. спортын холбоо, клубын байгууллагын соёл, менежментийг сайжруулах зорилгоор тамирчин, дасгалжуулагч, ажилтны ёс зүйн дүрмийг спортын холбоодтой хамтран боловсруулж, хэрэгжүүлэх.

3.3. Спортын шинжлэх ухаан, анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх суурь тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. биеийн тамир, спортын чиглэлийн мэргэжилтэн (бакалавр) бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтад олон улсын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг судалж, хэрэгжүүлэх;

3.3.2. төрийн захиалгаар гүйцэтгүүлэх судалгаа, шинжилгээ, туршилтын ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох;

3.3.3. биеийн тамирын арга зүйч, дасгалжуулагчдын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, иргэдэд зориулсан спортын сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;

3.3.4. биеийн тамир, спортын ажил үйлчилгээнд тавих хяналтыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

3.3.5. спортын шинжлэх ухааны төвийг байгуулж, спортын анагаах ухааны үйл ажиллагааны стандартыг батлуулах;

3.3.6. допингийн эсрэг үйл ажиллагааны үндэсний чадавхыг сайжруулах, хор хөнөөлийн талаарх сурталчилгааг нэмэгдүүлэх.

3.4. Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн зарим чиг үүргийг олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн спортын холбоо, түүний аймаг, нийслэл, дүүргийн салбар, магадлан итгэмжлэгдсэн спортын клубээр гүйцэтгүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.4.2. биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх;

3.4.3. “Спортыг дэмжих сан”-гийн хөрөнгийг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулах механизмыг бүрдүүлэх.

3.5. Биеийн тамир, спортын санхүүгийн менежментийг сайжруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. биеийн тамир, спортын арга зүйч, дасгалжуулагчдад мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдэл хөлс олгодог болох;

3.5.2. салбарын хэмжээний улсын төсвийн санхүүжилтийг газар зүйн байршил, хүн амын тоотой уялдуулж тооцох норм, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.5.3. биеийн тамир, спортын орчныг сайжруулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;

3.5.4. хүн амд үзүүлэх биеийн тамирын ажил үйлчилгээ, спортын амжилтын үр дүнд суурилан төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх системийг бүрдүүлэх, хяналт тавих тогтолцоог сайжруулах.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:



№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2019 он	Зорилтот түвшин	
					2021 он	2023 он
1.	Хүн амын зорилтот бүлгүүдийн сонирхол, бодит хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх	Бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн үр дүнг бие бялдрын хөгжлөөр дүгнэх	Хэрэг-жилтийн хувь	0	50	100
		Спортын дугуйлан (секц)	тоо	1731	1850	2000
		Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн А, В үнэлгээтэй хүн амын тоо	хувь	4.8	5.3	5.9
		Биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдаж байгаа хүн амын тоо	хувь	43	43.5	44
		Магадлан итгэмжлэгдсэн спортын клуб	тоо	0	15	30
		Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авсан спортын клуб	тоо	0	7	15
		Нэг хүнд ногдох спортын заалны талбайн хэмжээ	м.кв	0.23	0.24	0.24
		Нэг хүнд ногдох гадаа спортын талбайн хэмжээ	м.кв	1.91	1.93	1.95
2.	Спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх,	Аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид	тоо	1786	1939	2093
		Залуучуудын шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид	тоо	182	204	232
		Насанд хүрэгчдийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид	тоо	156	175	195



	тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах	Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүнд багтсан багийн спортын төрөл	тоо	1	2	3
		Үндэсний шигшээ багийн тамирчдын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль	тоо	44	47	50
		Үндэсний шигшээ багийн тамирчдын тивийн наадмаас авсан медаль	тоо	31	31	32
		Үндэсний шигшээ багийн тамирчдын авсан олимпын эрх	тоо	54	60	63
		Үндэсний шигшээ багийн тамирчдын олимпын наадмаас авсан медаль	тоо	4	7	9
3.	Спортын шинжлэх ухаан, анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх суурь тогтолцоог бүрдүүлэх	Биеийн тамир, спортын чиглэлээр мэргэжилтэн (бакалавр) бэлтгэж байгаа их, дээд сургуульд нэвтрүүлсэн олон улсын сургалтын хөтөлбөр	тоо	0	5	10
		Төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн (эрх авсан) ажилтан	тоо	0	100	200
		Төрийн захиалгаар эрдэм шинжилгээний байгууллагаас хэрэгжүүлсэн судалгаа	тоо	3	4	5



4.	Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн зарим чиг үүргийг олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн спортын холбоо, түүний аймаг, нийслэл, дүүргийн салбар, магадлан итгэмжлэгдсэн спортын клубээр гүйцэтгүүлэх	Сумдын биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн орон тооны ажилтан	тоо	10	21	299
		Төрийн байгууллагын ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэсэн төрийн бус байгууллага	тоо	62	66	71
5.	Биеийн тамир, спортын санхүүгийн менежментийг сайжруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх.	Татварын хөнгөлөлт, эдэлсэн аж ахуйн нэгж, байгууллага	тоо	0	20	30
		Улсын төсвийн санхүүжилтийг газар зүйн байршил, хүн амын тоотой уялдуулж төлөвлөх эрх зүйн орчинг бүрдүүлэх	хэрэг-жилтийн хувь	0	0	100

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив;
- 5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Биеийн тамир, спортын газар нь жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор тухайн жилд хийсэн ажлын тайлан, дүнг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн нэгдсэн тайланг биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага 11 дүгээр сарын 30-ны дотор биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.



6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн нэгдсэн тайланг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.4. Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг 2021 онд хийнэ. Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг улсын түвшинд биеийн тамир спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

6.5. Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жилд 2 удаа гүйцэтгэлийн хяналтыг хийнэ.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРМИЙН ТҮРЭМГИЙЛЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн оролцогч улсуудын 2010 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн Хяналтын бага хурлын 13 хуралдаанаас гаргасан 6 дугаар тогтоолоор баталсан.

1. Дүрмийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах.

2. Дүрмийн 8 дугаар зүйлийн дараа дараах эх бичвэрийг нэмэх:

8 bis дугаар зүйл

Түрэмгийллийн гэмт хэрэг

1. Энэхүү дүрмийн зорилгоор “түрэмгийллийн гэмт хэрэг” гэж аливаа улсын улс төрийн, эсхүл цэргийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх буюу ийм үйл ажиллагааг шууд удирдах албан тушаал бүхий этгээд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийг шинж чанар, ноцтой байдал, цар хүрээгээрээ илт зөрчсөн түрэмгийллийн үйлдлийг төлөвлөх, бэлтгэх, санаачлах, эсхүл гүйцэтгэхийг хэлнэ.

2. 1 дэх хэсгийн зорилгоор “түрэмгийллийн үйлдэл” гэж аливаа улс нөгөө улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эсхүл улс төрийн тусгаар тогтнолын эсрэг болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд харшлах аливаа бусад байдлаар зэвсэгт хүчин хэрэглэхийг хэлнэ. Дараах үйлдлийг дайны байдал зарласан эсэхээс үл шалтгаалан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1974 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 3314 (XXIX) дүгээр тогтоолын дагуу “түрэмгийллийн үйлдэл” гэж үзнэ. Үүнд:

а) Аль нэг улсын зэвсэгт хүчин нөгөө улсын нутаг дэвсгэрт халдан довтолох буюу дайрах, эсхүл ингэж халдан довтолсон буюу дайрсны үр дүнд түр хугацаанд ч гэсэн цэргийн хүчээр эзлэх, эсхүл нөгөө улсын нутаг дэвсгэрийг цэргийн хүчээр бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нэгтгэх;



b) Аль нэг улсын зэвсэгт хүчин нөгөө улсын нутаг дэвсгэрийг бөмбөгдөх, эсхүл нэг улс зэвсгийн аливаа төрлийг хэрэглэн нөгөө улсын нутаг дэвсгэрт халдах;

c) Аль нэг улс цэргийн хүчээр нөгөө улсын боомт буюу эргийг бүслэн хаах;

d) Аль нэг улсын зэвсэгт хүчин нөгөө улсын газрын, тэнгисийн буюу агаарын зэвсэгт хүчин, эсхүл усан болон агаарын хөлөгт халдах;

e) Хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт түүний зөвшөөрөлтэйгөөр байрлаж байгаа аль нэг улсын зэвсэгт хүчинг тухайн зөвшөөрөлд заасан нөхцлийг зөрчин ашиглах, эсхүл уг зэвсэгт хүчинг дээрх зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаа дууссанаас хойш тухайн нутаг дэвсгэрт үргэлжлүүлэн байлгах;

f) Аль нэг улс өөр улсад олгосон нутаг дэвсгэрээ тухайн өөр улс гуравдагч улсын эсрэг түрэмгийллийн үйлдэл хийхэд зориулан ашиглахыг зөвшөөрч буй аливаа үйлдэл;

g) Зэвсэгт хүчний дээр жагсаасан үйлдэлтэй дүйцэх ноцтой үйлдэл, эсхүл ийм үйлдэлд их хэмжээгээр оролцохтой дүйцэх үйлдлийг нөгөө улсын эсрэг гүйцэтгэж буй зэвсэглэсэн бүлэг, хэсэг, түр цэрэг болон хөлсний цэргийг аль нэг улс, эсхүл түүний нэрийн өмнөөс илгээх.

3. Дүрмийн 15 дугаар зүйлийн дараа дараах эх бичвэрийг нэмэх:

15 bis дугаар зүйл **Түрэмгийллийн гэмт хэргийг** **шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх** (Улсаас шилжүүлэх, өөрийн санаачлагаар ажиллах)

1. Шүүх түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг энэ зүйлийн заалтыг мөрдөхийн хамт 13 дугаар зүйлийн (а) болон (с) хэсэгт нийцүүлэн хэрэгжүүлнэ.

2. Шүүх энэхүү нэмэлт, өөрчлөлтийг гучин улс соёрхон баталсан буюу хүлээн зөвшөөрснөөс хойш нэг жилийн дараа үйлдсэн түрэмгийллийн гэмт хэргийн хувьд л шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж болно.

3. Шүүх түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлахад шаардлагатай оролцогч улсуудын олонхтой адил хэмжээний олонхын саналаар 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш батлах шийдвэрийн дагуу, энэ зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

4. Аливаа улс түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх Шүүхийн харьяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа Бүртгэгчид мэдэгдэл өгөх замаар урьдчилан зарласнаас бусад тохиолдолд Шүүх тухайн улсын түрэмгийллийн үйлдлээс үүссэн хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг 12 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлнэ. Дээрх мэдэгдлийг хэдийд ч эгүүлэн авч болох бөгөөд тухайн улс мэдэгдлийг эгүүлэн авах эсэхээ гурван жилийн дотор хянан үзнэ.

5. Энэхүү дүрэмд оролцогч бус улсын хувьд түрэмгийллийн гэмт хэргийг тухайн улсын иргэн үйлдсэн, эсхүл тус улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бол Шүүх шүүн шийдвэрлэх ажиллагаа хэрэгжүүлэхгүй.

6. Хэрэв түрэмгийллийн гэмт хэргийн хувьд мөрдөн байцаалт эхлүүлэх хангалттай үндэслэл байна гэж прокурор дүгнэвэл тэрээр тухайн улсын үйлдсэн түрэмгийллийн үйлдлийн талаар Аюулгүйн Зөвлөлөөс тодорхойлолт гаргасан эсэхийг эхний ээлжинд тодруулна. Прокурор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад Шүүхийн өмнө үүсээд буй нөхцөл байдлын талаар аливаа холбогдох мэдээлэл, баримт бичгийн хамт мэдэгдэнэ.

7. Хэрэв Аюулгүйн Зөвлөл ийм тодорхойлолт гаргасан бол прокурор түрэмгийллийн гэмт хэргийн талаар мөрдөн байцаалт эхлүүлж болно.

8. Мэдэгдсэнээс хойш зургаан сарын дотор ийнхүү тодорхойлолт гаргаагүй бөгөөд Урьдчилсан ажиллагааны танхим 15 дугаар зүйлд заасан журмын дагуу түрэмгийллийн гэмт хэргийн талаар мөрдөн байцаалт эхлүүлэх тухай зөвшөөрөл олгож, Аюулгүйн Зөвлөл 16 дугаар зүйлийн дагуу өөр шийдвэр гаргаагүй тохиолдолд прокурор түрэмгийллийн гэмт хэргийн талаар мөрдөн байцаалт эхлүүлж болно.

9. Түрэмгийллийн үйлдлийг Шүүхээс бусад байгууллага тодорхойлсон нь Шүүхээс энэхүү дүрмийн дагуу гаргасан дүгнэлтэд нөлөөлөхгүй.

10. Энэ зүйл нь 5 дугаар зүйлд дурдсан бусад гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтад нөлөөлөхгүй.

4. Дүрмийн 15 bis дугаар зүйлийн дараа дараах эх бичвэрийг нэмэх:

15 ter дугаар зүйл Түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх (Аюулгүйн Зөвлөлөөс шилжүүлэх)

1. Шүүх түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг энэ зүйлийн заалтыг мөрдөхийн хамт 13 дугаар зүйлийн (b) хэсэгт нийцүүлэн хэрэгжүүлнэ.

2. Шүүх энэхүү нэмэлт, өөрчлөлтийг гучин улс соёрхон баталсан буюу хүлээн зөвшөөрснөөс хойш нэг жилийн дараа үйлдсэн түрэмгийллийн гэмт хэргийн хувьд л шүүн шийдвэрлэх ажиллагаа хэрэгжүүлж болно.

3. Шүүх түрэмгийллийн гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлахад шаардлагатай оролцогч улсуудын олонхтой адил хэмжээний олонхын саналаар 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш батлах шийдвэрийн дагуу, энэ зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

4. Түрэмгийллийн үйлдлийг Шүүхээс бусад байгууллага тодорхойлсон нь Шүүхээс энэхүү дүрмийн дагуу гаргасан дүгнэлтэд нөлөөлөхгүй.



5. Энэ зүйл нь 5 дугаар зүйлд дурдсан бусад гэмт хэргийг шүүн шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой заалтад нөлөөлөхгүй.

5. Энэхүү дүрмийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дараа дараах эх бичвэрийг нэмэх:

3 bis. Түрэмгийллийн гэмт хэргийн хувьд энэ зүйлийн заалтыг аливаа улсын улс төрийн, эсхүл цэргийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх буюу ийм үйл ажиллагааг шууд удирдах албан тушаал бүхий этгээдийн хувьд хэрэглэнэ.

6. Энэхүү дүрмийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн эхний өгүүлбэрийг дараах өгүүлбэрээр солих:

1. Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь Шүүхэд 6, 7, 8, 8 bis дугаар зүйлийг тайлбарлах болон хэрэглэхэд дэмжлэг үзүүлнэ.

7. Энэхүү дүрмийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн толгой өгүүлбэрийг дараах хэсгээр солих, үлдсэн хэсгийг хэвээр үлдээх:

3. Хэрэв өөр шүүхээс явуулсан шүүх ажиллагаа нь дараах тохиолдолд бус бол, түүнчлэн 6, 7, 8 эсхүл 8 bis дугаар зүйлийн дагуу мөн хориглосон үйлдлийн төлөө өөр шүүхээр шийтгэгдсэн ямар ч хүнийг тухайн үйлдлийн төлөө Шүүхээс шийтгэл ногдуулж болохгүй.

ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРМИЙН ДАЙНЫ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ 8 ДУГААР ЗҮЙЛИЙН НЭМЭЛТ

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн оролцогч улсуудын 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн Хяналтын бага хурлын 12 хуралдаанаас гаргасан 5 дугаар тогтоолоор баталсан.

8 дугаар зүйлийн 2(e) дэд хэсэгт дараах эх бичвэрийг нэмэх:

xiii) хор, эсхүл хордуулсан зэвсэг хэрэглэх.

xiv) Амьсгал боогдуулагч, хортой буюу тэдгээртэй ижил төрлийн хий, бусад бүх төрлийн шингэн, бодис болон хэрэгслэлийг хэрэглэх.

xv) гадаргуугаараа хатуу бүрхүүлтэй, тэрхүү бүрхүүл нь сумын цөм хэсгийг бүхэлдээ бүрхээгүй, эсхүл ир бүхий цоорхойтой сум, иймэрхүү хүний биед амархан тэлдэг буюу хүний биеийг юу ч үгүй болтол нь эвдэн сүйтгэх сум хэрэглэх.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003